

Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэл түгээх өдөрлөгийн үеэр “Нээлттэй мик” арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээний удирдамж

Зохион байгуулагч: ХИС-гийн “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төсөл

Байршил: Налайх дүүргийн төв талбай

Хугацаа: 2025 оны 5-р сарын 3 (Бямба гараг)

Үндэслэл

Төслийн үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг болох олон нийтэд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мэдээллийг түгээх сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд **“Урт наслаарай дэлхий ээжээ” Climate campaign ба open mic** өдөрлөгийг 2025 оны хавар буюу 5 дугаар сарын 3-нд зохион байгуулахаар бэлтгэж байна. Тус өдөрлөгийг зохион байгуулснаар дүүргийн хүүхэд, залуучууд иргэд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг сонирхолтой хэлбэр, агуулгаар тодорхой сэдвүүдийн хүрээнд өөрсдийн мэдлэг, мэдээллээ бусадтайгаа хуваалцах боломжоор хангагдана.

Өдөрлөгийн зорилго

Налайх дүүргийн хүүхэд, залуучууд, иргэдийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах талаар мэдлэгтэй болгож, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, урт хугацаанд байгальд ээлтэй зан үйлийг сурталчлах зорилготой.

- Open Mic арга хэмжээгээр Нийслэлийн Налайх дүүргийн +300 хүүхэд залуучууд, иргэдийг татан оролцуулах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мэдээлэл түгээх.
- Иргэдийг "Мод тарих өдөр"-т бэлтгэх, мэдлэг, сонирхлыг нэмэгдүүлэх,
- Оролцогчдод бодитой үйлдэл хийх уриалга өгөх (жишээ нь: мод тарих, хог хаягдлаа багасгах амлалт авах)
- Залуу үеийнхний идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх: Нээлттэй микашиглах замаар дуу хоолойгоо сонсгох, уран бүтээл (шүлэг, дуу, зураг) дамжуулан сэтгэлгээг илэрхийлүүлэх,

Зохион байгуулагчид тавих шаардлага

1. Гадаа задгай талбайд олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж байсан туршлагатай, өөрсдийн албан ёстой сошиал медиа платформуудтай, зохих хэмжээний дагагчидтай байх буюу үйл ажиллагааны чиглэлээрээ нийтэд танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн байх,
2. Мэргэжлийн дуугаралттай хөгжим аппарат, хэрэгсэл ашиглах: Гадаа задгай талбайд мэргэжлийн дуугаралттай хөгжим аппарат суурилуулах,
3. Promo видео зарлал гаргах: Арга хэмжээний promo видео зарлал бэлтгэх, гаргах,
4. Үйл ажиллагаа зохион байгуулах талбай буюу Налайх дүүргийн төв талбайг үйл ажиллагаа зохион байгуулахаас өмнө очиж танилцах,
5. Highlight videos болон өндөр чанартай дүрс бичлэг: Арга хэмжээний highlight videos болон үйл ажиллагааны өндөр чанартай, мэргэжлийн дүрс бичлэг авч, монтажлан, захиалагчид хүлээлгэж өгөх,
6. 2-3 цагийн арга хэмжээг зохион байгуулах: Арга хэмжээг 2 цагийн турш үргэлжлүүлэхэд шаардлагатай техник мэргэжлийн болон хөтлөлт, идэвхжүүлэлтийн мэргэжлийн багтай байх,

Техникийн болон үнийн санал хүлээн авах

Техникийн болон үнийн саналыг 2025 оны 04 дугаар сарын 14-ны өдрийн 17:00 цагаас өмнө mongolia.procurement@savethechildren.org хаягаар хүлээн авна.

Бүрдүүлэх материал

Сонирхсон өргөдөл гаргагчид дараах материалыг ирүүлнэ үү:

1. Үйл ажиллагааны төлөвлөгөө.
2. Танилцуулга /Баг хамт олон болон техник мэргэжлийн аппарат хэрэгсэл зэрэг/
3. Үнийн санал /НӨАТ болон холбогдох татвар даатгал орсон дүнгээр/
4. Адил төстэй үйл ажиллагаа амжилттай хийж гүйцэтгэсэн 3 -с доошгүй ажлын линк